



“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088
Цахим шуудан: www.shonkhor.mn
И-мэйл: shonkhor@gmail.com

2019.04.04 № 19/30
танай _____ -ны № _____ -г

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид “Хөнгөн бетон” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Хөнгөн бетон” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх баланс, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана.

Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч, Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

(Энэхүү тайлан нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

